

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн
278 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар

Албан тушаалын нэр:

Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн төв

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг

Онцгой нөхцөл:


Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хүрээнд нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийг хөгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нийгмийн эрүүл мэндийн төвийн даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u> 1.Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого шийдвэр, стратегийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хянах, тайлагнах; 2.Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн тогтвортой үйл ажиллагаа явуулах, салбар дундын оролцоог хангах, нэгж байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих; 3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.				
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх–Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт, хүн амын хөдөлгөөний идэвхийг сайжруулахад чиглэсэн хууль, үндэсний хөтөлбөр, стратегийг орон нутагт хэрэгжүүлэх талаар ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, хяналт тавих,тайлагнах;	Үйл ажиллагааг зохион байгуулсан байна.		Г
	2.Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагаанд бусад салбарын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, хамтрагч байгууллагуудын дунд мэдээлэл солилцох мэргэжил арга зүйгээр хангаж үр дүнг тооцож ажиллах.	Хэрэгжүүлэн ажилласан байна.		Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Биеийн тамир, спортоор хичээллэх, алхах, дугуйгаар явахад тохиромжтой, аюулгүй зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ашиглалтыг сайжруулах талаар орон нутгийн бодлогод тусгуулах, хэрэгжилтийг сайжруулах талаар бодлого, боловсруулагч шийдвэр гаргагч нарт зориулсан ухуулга	Ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.		Г



нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, энэ талаарх бодлого, арга хэмжээг мэргэжил, арга зүйгээр хангаж хяналт тавьж ажиллах;			
2.Байгууллага, хамт олны дунд биеийн тамир, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнийг идэвхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах;	Мэргэжил арга зүйгээр хангасан байна.		Г
3.Бүх шатны боловсролын байгууллагын чөлөөт цаг, хичээлийн бус цагаараа бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн тамираар хичээллэх нөхцөл бололцоог хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;	Дасгал хийж хэвшсэн сурагчдын тоо.		Г,Х
4."30 минут өөртөө зарцуулья", "өдөрт 10000 алхам алхая" болон аэробик, нийтийнбүжиг, явган аялал, гүйлт, хийн болон йогийн дасгал зэрэг бүх нийтийг хамарсан арга хэмжээг өргөжүүлэх ажлыг зохион байгуулах;	Нийтийн хамарсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн мэдлэг, хандлага дээшилнэ.		Г
5. Хүн амын хөдөлгөөний хомсдлыг тандан судлах, орон нутгийн хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшинг тогтоох, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Судалгааны үр дүнд суурилсан төлөвлөгөөг хэргэжүүлэн ажилласан байна.		Г
6.Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын үйлчилгээний одоогийн байдалд үнэлгээ өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллах;	Хамтран ажилласан байна.		Г
7.Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, идэвхтэй хөдөлгөөний талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах ажлыг зохион байгуулах;	Үйл ажиллагааг зохион байгуулсан байна.		



	8.Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, идэвхтэй хөдөлгөөний талаар сургалт явуулах эмч, аргазүйч, сайн дурын идэвхтэнд зориулсан гарын авлага, удирдамж боловсруулж, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах;	Мэргэжил арга зүйгээр хангасан байна.	Г
	9.Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагыг сурталчлах, тэдний туршлагыг олон нийтийн хүртээл болгох, үр дүнг тооцох.	Үр дүнг тооцон ажилласан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;	Ёс зүйн зөрчил гаргасан эсэх.	Г
	2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;	Ашиг сонирхлын зөрчил гаргасан эсэх.	Г
	3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	Хэрэгжилтийн хувь.	Г
	4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх;	Биелэлтийн хувь.	Г
	5.Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах;	Хэрэгжилтийн хувь.	Г
	6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;	Хэрэгжилтийн хувь.	Г
	7.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийн хувь.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	Анагаах ухаан /0912/, Багш, биеийн тамирын боловсрол /0114/.		



IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй.

Бусад харилцах субъект

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ажлын албаны холбогдоо
ажилтан;

-Аймаг, сумдын Засаг даргын Тамгын
газрын холбогдох албан тушаалтан;

-Эрүүл мэндийн бусад байгууллагууд;

-Төрийн болон төрийн бус байгууллагууд;

-Иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:

ЭДИЙН ЗАСАГ, УДИРДЛАГА
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БААСАНДОРЖ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19...11 04

Дугаар: 278...

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

ДАРГА

[Signature]

Ц.ГЭРЭЛМАА

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

